



СЭЛЭНГЭ АЙМАГ
БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/304

Баруун хараа

Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн
ээлжит тооллого явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 "в", Засгийн газрын 2003 оны 10 дугаар сарын 14-ний 224 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 172 дугаар захирамж, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/504 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад хашаа, худгийн тооллогыг 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс 12 дугаар сарын 17-ны өдрийн хооронд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ө.Жавхлантөгс (Засаг даргын орлогч)
Гишүүдэд:	Р.Сэлэнгэ (Хараа 1 дүгээр багийн Засаг дарга) Д.Цэрэндулам (Баян 2 дугаар багийн Засаг дарга) А.Бадамцэцэг (Гонир 3 дугаар багийн Засаг дарга) Г.Баясгалан (Санхүүгийн албаны дарга) Г.Тольдэлбээ (Нийгмийн бодлогын мэргэжилтэн) Б.Угтахбаяр (Татварын улсын байцаагч) Д.Батцэцэг (Хөдөө аж ахуйн тасгийн мал зүйч) Ц.Золзаяа (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	Д.Алтанцэцэг (Статистик хариуцсан мэргэжилтэн)

2. Ажлын хэсэгт ДААЛГАХ нь:

а) Сумын хэмжээнд тооллого зохион байгуулах ажлын хэсгийг томилон ажиллуулж, тогтоосон хугацаанд тооллогын дүнг ажлын хэсэгт хүлээлгэн өгөх

б) Тооллогын ажлын хэсэгт ажиллахаар томилогдсон албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлж, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, малыг тоолж, маягтад бүртгэсний дараа малын эзэн, тооллогын комиссын гишүүдээр гарын үсэг зуруулж баталгаажуулах, малгүй болсон, шилжсэн өрхийн мэдээллийг сайтар нягтлах, малын орлого зарлагын хөдөлгөөнийг үнэн бодитоор хөтлөх

в) Малчдын нийгмийн асуудлыг шийдэх, сүү, ноос, ноолуурын урамшуулал олгох зэрэгт мал, тэжээвэр амьтдын тооллогын мэдээллийг нотолгоо болгон авч ашиглаж байгаа тул тооллогод хамрагдах малтай өрх, аж ахуй нэгж, байгууллагын бүртгэлийг урьдчилан гаргаж, шинээр нэмэгдсэн болон шилжин ирсэн өрх, аж ахуй нэгж, байгууллагыг тооллогод бүрэн хамруулах

г) Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 өнөөс хэрэгжиж байгаатай холбогдуулан малын тоон мэдээллийг нуун дарагдуулахгүй байх, зохиомол өрх үүсгэхгүй байхад анхаарах

д) Тооллогод ажиллах албан хаагчдад халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулж, нэг удаагийн маск, бээлий, спиртэн суурьтай гар ариутгагч зэргээр хангах

е) Малчин өрхийн хог хаягдлын хураамжийг бүрэн оруулах

3. Багийн Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

а) 2022 оны Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого зохион байгуулах ажлын төлөвлөгөө баг тус бүрээр гаргаж батлуулах.

б) Баг бүрт багийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилох.

в) Багийн хэмжээнд тооллогын ажлыг зохион байгуулахад шаардлагатай хүн хүч, машин техникийн судалгаа гаргах, шатахууны төсөв, маршрутыг гаргаж батлуулах.

г) 2022 оны Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогын талаарх мэдээллийг иргэдэд хурдан шуурхай хүргэх, цахим хаягаар мэдээлэл хүргэх, малаа бэлэн байлгах талаар малчдад мэдэгдэх.

д) Тооллогын үеэр ажиллаж буй албан хаагчдын аюулгүй байдлыг хангаж ажиллах.

е) Ажлын хэсгийг мэдээ мэдээллээр бүрэн хангах.

ё) Малчин болон мал бүхий иргэдийн малын тоо толгойн албан татвар, өрхийн хог хаягдлын хураамжийг бүрэн оруулах.

4. Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн ээлжит тооллогын ажилд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж батлуулан Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүүгийн албаны дарга (Г.Баясгалан)-д зөвшөөрсүгэй.

5. Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогод шаардлагатай ажиллах хүчээр хангах, томилогдсон албан хаагчдад цалинтай чөлөө олгож ажиллахыг төр, төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

6. Цаг агаарын нөхцөл байдлын мэдээ, мэдээлэл хүргэж хамтарч ажиллахыг Баруунхараа УЦУС-ын дарга (Н.Мөнхсайхан), цаг агаарын аюултай үзэгдэл, учирч болзошгүй эрсдэлийн бэлэн байдалд анхаарч ажиллахыг Гал түймэр унтраах, аврах 40 дүгээр ангийн захирагч (Ж.Эрдэнэцогт), малын хулгайтай тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор 3 багийн нутаг дэвсгэрт сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэж, эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулахыг Цагдаагийн хэсгийн дарга, Цагдаагийн ахмад (М.Отгонбаяр) нарт үүрэг болгосугай.

7. 2022 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн ээлжит тооллогыг холбогдох хууль эрх зүйн акт, журам, зааврын дагуу удирдлага зохион байгуулалтаар сайтар хангаж, төлөвлөгөө гарган, мал тооллогод ажиллаж буй албан хаагч, тоологч нарт семинар зохион байгуулах, тооллогын үе шат бүрт хяналт тавьж ажиллах, заасан хугацаанд дүн мэдээ тайланг маягтын дагуу авч, дүнг нэгтгэн аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч, Засаг даргын орлогч (Ө.Жавхлантөгс)-д даалгасугай.

8. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Эрдэнэбаатар)-д даалгасугай.



P. БАТЖАРГАЛ